



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 455

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хавсралтад заасан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 17,350,000.00 (арван долоон сая гурван зуун тавин мянга) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины ашиглах хугацаа үнийг шинэчлэн тогтоож Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын дарга Т.Даваадорж, Дорноговь аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Б.Адилбиш нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дугаар сарын 22 өдрийн
4.5.5 дугаар тогтоолын хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ /төгрөг/	Ашиглах хугацаа
1	Тоёота Гранд марк-2 0300 ДГО, арал GX1106066653	2003/2011	17,350,000.00	17,350,000.00	0.00	2,000,000.00	2
			17,350,000.00	17,350,000.00		2,000,000.00	
	Нийт дүн		(арван долоон сая гурван зуун тавин мянга)			(хоёр сая)	